



СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ


Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер дилер

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ МЭДЭЭ


2020 оны 5-р сар

МХБ-ийн индексүүд

Топ-20 индекс, 15,960 **-2.7%** (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)



МХБ-А индекс, 7,722 **+0.5%**, МХБ-В индекс 7,254 **-2.7%** (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)



Олон улсын индексүүд

Индекс	2019.04.30	2020.05.29	Өөрчлөлт, %
DJIA (US)	24,345	25,383	4.2%
S&P 500 (US)	2,912	3,044	4.5%
Nikkei 225 (JP)	20,193	21,877	8.3%
Hang Seng (HK)	23,613	22,961	-2.7%
DAX 30 (DE)	10,861	11,586	6.6%
SMI (CH)	9,629	9,831	2.0%

Валютын ханш

Валют	2019.04.30	2020.05.31	Өөрчлөлт, %
USD	2,777.74	2,805.97	1.0%
EUR	3,054.54	3,115.89	2.0%
JPY	25.62	26.18	2.1%
RUB	35.37	39.64	12.0%
CNY	391.62	392.59	0.24%
KRW	2.28	2.27	-0.4%

Арилжааны мэдээ

Хураангуй (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)

Үзүүлэлт	Дүн	Өөрчлөлт, %
Арилжааны хэмжээ, тэрбум ₮	4.4	+96.8%
Зах зээлийн үнэлгээ, тэрбум ₮	2,415.7	-0.5%
Бүртгэлтэй компани	198	198
Арилжаалагдсан хувьцаа	66	-3
Арилжаалагдсан өдөр	21	-1

Хамгийн их өсөлттэй

Хувьцаа	2019.04.30	2020.05.29	Өөрчлөлт, %
AMT	225.00	290.00	+28%
HSG	2,242.00	2,598.00	+15%
GTJ	603.88	694.00	+15%
HUZ	430.22	494.00	+15%
ETR	139.00	158.00	+13%

Зах зээлийн мэдээлэл

МХБ бүртгэлтэй компаниудын хурал хуралдуулах хугацаа дууслаа

Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаат компаниуд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа жил бүрийн 5-р сарын 1-ний дотор зарлан хуралдуулах үүрэгтэй. Энэ жилийн хувьд МХБ-д бүртгэлтэй компаниудаас 143 хувьцаат компани буюу 72% нь хурлаа хуралдуулжээ. Хуулийн хугацаанд хурлаа хуралдуулаагүй тохиолдолд ТУЗ-ийнх нь бүрэн эрх дуусгавар болдог.

ҮЦТХТ-д нээгдсэн дансны мэдээлэл

ҮЦТХТ-д 5-р сард нийт 208,926 данс нээгдсэнээс 152,192 данс шинээр, 56,734 данс холболтоор нээгдсэн ба шинээр нээгдсэн дансдын бүтцийг харвал 152,163 дотоодын иргэн, 2 гадаадын иргэн, 27 дотоодын аж ахуйн нэгжийн данс тус тус нээгдсэн байна. 2020 оны 5-р сарын байдлаар Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцаа эзэмшигч 2.5 сая гаруй иргэнээс 850 гаруй мянга нь үнэт цаасны данс нээлгээгүй, үнэт цаасны дансаа нээлгэсэн 1.6 сая гаруй иргэн байгаагаас дөнгөж 700 гаруй мянган иргэн нь өөрийн нэр дээрх арилжааны банкны дансаа холбуулсан байгаа тухай эх сурвалжууд мэдээлсэн. Та дансаа холбуулах мэдээллийг манай цахим хуудасны дараах линкээр орж харна уу. http://www.standardinvestment.mn/mn/home/newsmore_page/18/0/238

Бодь даатгал IPO

МХБ Бодь даатгал ХК-ийн нийт 235,319,718 ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлийн I ангилалд бүртгэснийг СЗХ хэлэлцэж, нийт хувьцааны 20% буюу 47 сая ширхэг хувьцааг анх удаа олон нийтэд санал болгон худалдах зөвшөөрлийг 2019.12.27-нд олгосон. Тус хувьцааны (MSE:BODI) анхдагч зах зээлийн захиалгыг 2020 оны 5-р сарын 25-наас 6-р сарын 8-ны хооронд авахаар болсон байна. Бодь даатгал ХК-ийн олон нийтэд арилжаалах хувьцааны 60% буюу 35.2 сая ширхгийг стратегийн хөрөнгө оруулагчдад тогтоосон үнийн аргаар буюу нэгж хувьцааг 113 төгрөгөөр, 20% буюу 11.7 сая ширхгийг захиалгын бүртгэлийн аргаар буюу нэгжийн үнийг 113-135 төгрөгийн хооронд нийтэд санал болгон худалдаж, нийт 5.3-5.58 тэрбум төгрөг татан төвлөрүүлэх бөгөөд үүнийг хөрөнгө оруулалт, технологийн хөгжүүлэлт, сайжруулалтанд зарцуулахаар төлөвлөж байгааг үнэт цаасны танилцуулганд дурджээ. http://mse.mn/uploads/ipo/bodi_prospectus.pdf

ЛэндМН ХК нээлттэй бонд гаргана

ЛэндМН ХК-ийн анхны олон нийтэд нээлттэй бонд гаргах үйл ажиллагаа МХБ болон СЗХ-ноос зөвшөөрөл авах шатандаа явж буй юм байна. Тухайн бонд нь жилийн 17%-ийн хүүтэй, 1 жилийн хугацаатай, хүү болон үндсэн төлбөрөө хугацааны эцэст төлөх нөхцөлтэй ба нийт 5 тэрбум төгрөг олон нийтээс татах зорилготой аж. Компанийн нээлттэй бондын хувьд 2020 оноос эхлэн ХХОАТ-ын тухай хуулийн 21.5 зүйлд заасны дагуу хүүгийн орлогод ногдох татвар нь 5% болсон юм.

Түмэн шувуут ХК-ийн компост бордооны үйлдвэр нээгдлээ

Түмэн шувуут ХК-ийн үнэт цаасны танилцуулгадаа тусгаж төлөвлсөн 4 томоохон ажлын нэг нь цэвэр байгалийн гаралтай, 100% компост бордооны үйлдвэр барих барилга байгууламжийн ажил юм. Түмэн шувуут ХК нь эдийн засгийн энэхүү хүнд нөхцөлд тус үйлдвэрийг төлөвлөгөөний дагуу амжилттай байгуулж, энэ оны 5-р сард ашиглалтад оруулсан байна. Энэхүү үйлдвэр нь тахианы сангасыг дэвшилтэт технологиор боловсруулж, Монгол орны байгаль цаг уур,

Хамгийн их бууралттай

Хувьцаа	2020.04.30	2020.05.29	Өөрчлөлт, %
DAR	4250.00	2,825.00	-33%
UID	900.00	611.00	-32%
TCK	14,000.00	11,000.00	-21%
DRU	800.00	650.00	-18%
SOH	41.62	34.00	-18%

Хамгийн их арилжигдсан

Хувьцаа	Тоо ширхэг	Үнийн дүн. сая төг	Эзлэх %
MFC	14,721,369	1,208.6	26.9%
MNP	27,604	616.1	13.7%
ADL	568,730	600.5	13.3%
SOH	13,589,549	480.5	10.7%
ADB	4,967,667	388.2	8.6%

Зах зээлийн үнэлгээ хамгийн их өссөн, тэрбум төгрөгөөр

Компани	2020.04.30	Өөрчлөлт	Өөрчлөлт, %
AMT	3.5	1.0	+28.8%
HSG	0.663	0.99	+14.9%
GTJ	0.344	0.51	+14.9%
HUZ	0.40	0.6	+14.8%
ETR	6.4	0.877	+13.6%

Зах зээлийн үнэлгээ хамгийн их буурсан, сая төгрөгөөр

Компани	2020.04.30	Өөрчлөлт	Өөрчлөлт, %
DAR	2,612.0	875.8	-33.5%
UID	33,127.0	10,637.4	-32.1%
TCK	14,331.8	3,071.1	-21.4%
DRU	243.0	45.5	-18.7%
SOH	571.6	104.6	-18.3%

хөрсний онцлогт нийцсэн, органик бордоо үйлдвэрлэнэ. Ийнхүү ногоон байгууламж, газар тариалан эрхлэгчдэд чухал хэрэгцээтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн нь хөдөө аж ахуйн салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулна гэж салбарын сайд онцолсон байна.

Евразиа капитал холдинг ХК нь Люкс зананду групп ХК-тэй нэгдэнэ

МХБ-ийн III ангилалд бүртгэлтэй компаниуд болох Евразиа капитал холдинг ХК (MSE:SUN) болон Люкс зананду групп ХК (MSE:BAZ) хоорондоо нэгдэж, цаашид үйл ажиллагаа явуулах шийдвэрлэжээ. Евразиа капитал холдинг ХК-ийн хувьд хөрөнгийн зах зээл дээр брокер, дилерийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бол Люкс зананду групп ХК нь программ хангамж хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Баянгол зочид буудал ХК нийт хувьцааныхаа 5.9%-ийг халааслана

Баянгол зочид буудал ХК-ийн (MSE:BNG) хувьцаа эзэмшигч болох БиДиСек ҮЦК ХК нь эзэмшлийн хувь болох нийт хувьцааны 5.9%-тай тэнцэх 25,000 ширхэг хувьцаагаа худалдах санал гаргасан тул компанийн зүгээс тус хувийг эргүүлэн худалдан авахаар болсон байна. Одоогоор хэлцлийн дүн тодорхойгүй байгаа бөгөөд зах зээлийн ханшаар тооцвол 800 орчим сая төгрөгийн үнэлгээтэй байна. Хувьцаагаа эргүүлэн худалдаж авах буюу халааслах асуудлыг өнгөрсөн сард болсон Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа хэлэлцэн шийдвэрлэж, ТУЗ-д эрхийг нь олгожээ.

Та цахимаар дансаа нээж, арилжаа хийхийг хүсвэл манай “Цахим данс” системд бүртгүүлээрэй. Мөн гар утасны аппликэйшн татан авч, онлайнар дансаа нээж, арилжаа хийх боломжтой.

“ЦАХИМ ДАНС” СИСТЕМ

<https://dbx.standardinvestment.mn/>

Standard Investment

Available on the App Store

ANDROID APP ON Google play

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

Эх сурвалж: Монгол улсын үндэсний статистикийн хороо



МӨНГӨ, ЗЭЭЛ


Мөнгөний нийлүүлэлт (M2) 2020 оны 5-р сарын эцэст 20.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 259.9 (1.3%) тэрбум төгрөгөөр өсөхөд валютын хадгаламж 1,046.8 (35.7%) тэрбум төгрөгөөр, валютын харилцах 62.5 (2.7%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2020 оны 5-р сарын эцэст 974.1 тэрбум болж, өмнөх сараас 115.6 (13.5%) тэрбум төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 34.4 (3.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна. *Хүснэгт. Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, жилийн эцэст, тэрбум төгрөг*

Үзүүлэлт	2019.05	2020.05*
Мөнгө M2	20,300.4	20,560.3
Бага мөнгө M1	3,796.8	3,626.0
Төгрөгийн харилцах	3,130.2	2,925.1
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	666.7	700.9
Бараг мөнгө	16,503.5	16,934.3
Төгрөгийн хадгаламж	11,286.3	10,607.8
Валютын хадгаламж	2,929.7	3,976.5
Валютын харилцах	2,287.5	2,350.0
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	939.7	974.1

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 5-р сарын эцэст 17.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 16.6 (0.1%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 795.6 (4.4%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 5-р сарын эцэст 1.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 161.4 (12.3%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 324.6 (39.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2020 оны 5-р сарын эцэст 1.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 100.9 (5.4%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оны мөн үеэс 2.3 (0.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зураг 29. Чанаргүй зээл, 5-р сарын эцэст, тэрбум төгрөг




УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн нийт хэмжээ 2020 оны 5-р сарын урьдчилсан гүйцэтгэлээр 3.6 их наяд төгрөг, үүнээс нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж нь 3.3 их наяд төгрөг болж нийт орлогын 93.8 хувийг эзэлж байна. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 4.9 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.




ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2020 оны 4-р сарын урьдчилсан гүйцэтгэлээр 874.1 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 442.3 сая ам. доллараар өсчээ. Урсгал данс 874.1 сая ам.долларын алдагдалтай гарахад үйлчилгээний тэнцэл 367.8 сая ам.доллар, анхдагч орлогын данс 215.0 сая ам.долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.



ГАДААД ХУДАЛДАА

Монгол Улс 2020 оны эхний таван сард нийт 131 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 4.0 тэрбум ам. доллар, үүнээс экспорт 2.0 тэрбум ам. доллар, импорт 2.0 тэрбум ам.долларт хүрлээ. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.6 (28.3%) тэрбум ам.доллар, үүнээс экспорт 1.3 (38.5%) тэрбум ам. доллароор, импорт 322.6 (13.9%) сая ам. доллараар тус тус буурчээ.




Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2019 оны 5-р 948.3 сая ам. долларын ашигтай гарч байсан бол 2020 оны 5-р сард өмнөх оны мөн үеэс 934.5 сая ам.доллараар буурч, 13.9 сая ам.долларын алдагдалтай байна.



ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 5-р сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.1 хувиар буурч, өмнөх оны эцсээс 2.4 хувь, өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар өссөн байна.



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 5-р сард өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 4.7 хувь (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 4.5 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 3.9 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 4.7 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 5.0 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 4.5 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 4.3 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн хэдий ч тээврийн бүлгийн үнэ 6.8 хувиар буурсан байна.

Холбоо барих хаяг

Стандарт инвестмент ҮЦК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
6-р хороо, Бага тойруу 24,
Монреимпекс ХХК-ийн байр,
2-р давхар, 201 тоот

Утас: 70114433
info@standardinvestment.mn
www.standardinvestment.mn

Шуудангийн хаяг:

Төв шуудан, Шуудангийн хайрцаг 1487
УБ - 15160

Тодруулга болон мэдэгдэл

Энэхүү тойм мэдээ нь ямар нэгэн үнэт цаасыг худалдан авах, худалдах санал биш юм. Энд дурдсан үнэ ханшийн мэдээ, бусад тоон мэдээлэл, тайлбар зэрэг нь зөвхөн тухайн мэдээллийг бэлтгэх үеийн байдлыг илтгэх бөгөөд өөрчлөгдөж, хувьсаж болно /Стандарт инвестмент ҮЦК өөрчлөлтийг мэдэгдэх албагүй/. Хөрөнгө оруулагч эрсдлийг өөрөө хариуцна.

Энэхүү тойм мэдээний бүх мэдээллийг зөвхөн мэдээлэл өгөх зорилгоор бэлдсэн бөгөөд найдвартай, сайн санааны үүднээс гаргасан гэж үзсэн эх сурвалжаас авч боловсруулсан хэдий ч мэдээлэл тус бүрийг нэг бүрчлэн хянаж шалгаагүй болно. Тиймээс Стандарт инвестмент ҮЦК нь эдгээр мэдээллийн үнэн зөв, бодит бөгөөд бүрэн бүтэн байдалд баталгаа гаргахгүй бөгөөд мэдээллийг дамжуулахаас үүссэн аливаа алдааг хариуцахгүй. Түүнчлэн, энэхүү тайланг ашигласнаас учирсан аливаа хохиролд Стандарт инвестмент ҮЦК ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

©2020 *Стандарт инвестмент ҮЦК*